



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 98

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын албан хэрэгцээнд аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр бэлтгэсэн 199,455,000 /нэг зуун ерэн есөн сая дөрвөн зуун тавин таван мянган / төгрөгийн өртөгтэй Toyota land Cruiser 200 маркын суудлын автомашиныг үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.


Хоёр: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга (Ц.Мөнгөнцоож)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

